



**ҮАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын 2014 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн аудит*

Аудитын код: ҮАГ-2015/21/СТА-ТШЗ

2015 оны 2 дугаар сар

Улаанбаатар хот

<b>НЭГ. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ</b>	2
<b>ХОЁР. АУДИТЫН ТАЙЛАН</b>	4
2.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:	5
2.2 Байгууллагын хууль, эрх зүйн орчин:	5
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:	6
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:	6
2.5 Дотоод хяналт:	7
2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	8
2.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:	8
2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:	8
2.10 Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд:	8
2.10.1 Үндсэн бус үйл ажиллагааны орлогын талаар	8
2.10.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн талаар	9
2.10.3 Автомашины ашиглалт, зориулалт, түлш, шатахууны зардлын талаар	9
2.10.4 Үндсэн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах талаар	9
2.10.5 Төрийн өөрийн хөрөнгийн талаар	10
2.11 Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:	10
2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:	10
2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:	10
2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	10
2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	11
2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
2.17 Шилэн дансны мэдээлэл	11
<b>ГУРАВ. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ</b>	12
3.1 Менежментийн захидлын тайлбар, тодруулга:	13
3.2 Аудитын зөвлөмж:	13
Дөрөв. Баталгаажуулалт:	16
4. Хавсралт:	17
Хавсралт №1 Аудит хийсэн санхүүгийн тайлан	17
Хавсралт №2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	25
Хавсралт №3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт	27



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦЕГ-ЫН АВТОБААЗЫН  
ДАРГА С.САРУУЛ ТАНАА

2015.02.16 № 3/2014  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЦЕГ-ын Автобаазын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

ЦЕГ-ын Автобаазын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

*Зөрчилгүй санал дүгнэлт*

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

## ХОЁР. АУДИТЫН ТАЙЛАН



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ЦЕГ-ЫН АВТОБААЗЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл

Утас: 260512

Цахим хаяг: odgerell@audit.gov.mn

Ж.Батсайхан

Цахим хаяг:

batsaikhanj@audit.gov.mn

Утас: 261839

Үндэсний аудитын газар

Засгийн газрын IY байр  
Бага тойруу 6  
Улаанбаатар-46  
Монгол улс

Цахим хуудас: [www.mnao.mn](http://www.mnao.mn)

2014 оны 2 дугаар сар

## АУДИТЫГ ДУУСВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

Агуулга

Оршил

Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс,  
гаргасаншийдлүүд

Залруулаагүй алдаа

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын санал дүгнэлт

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын санал дүгнэлт

## **2.1 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ЦЕГ-ын Автобаазын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2014 оны 1 дүгээр сарын 25-наас 2014 оны 2 дугаар сарын 10-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ынахлах аудитор Ж.Батсайхан хэрэгжүүлэв.

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 1 дүгээр сарын 25-наас 2014 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд ЦЕГ-ын Автобаазын удирдлагад гардуулна.

## **2.2 Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

ЦЕГ-ын Автобаазын төсвийн захирагч нь Монгол улсын "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз нь Цагдаагийн албаны тухай хуулийн 13.1-д заасан Цагдаагийн байгууллагын үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахаас гадна дараахь чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ биелүүлэхэд албаны болон тусгай зориулалтын автомашинаар албаны бэлэн байдлыг ханган түргэн шуурхай үйлчлэх
- Албаны болон тусгай зориулалтын автомашины засвар үйлчилгээг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх
- Үйлчилгээнд явж байгаа автомашинуудад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу стандарт, норм, нормативыг мөрдөж ажиллах
- Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай хүний нөөцөөр хангах
- Цагдаа жолооч, засварчин болон ажиллагсадын мэдлэг боловсрол, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу ЦЕГ-ын Автобаазын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. ЦЕГ-ын Автобаазын төсвийн 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЦЕГ-ын Автобаазын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалсан.

### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил17-г гүйцэтгэв.

ЦЕГ-ын Автобаазын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна.

Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдэж байгаа хууль эрх зүйн орчин, стандарттай нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

ЦЕГ-ын Автобаазын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Аcolose програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## **2.5 Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд ЦЕГ-ын Автобаазын дотоод хяналтыг системийг эрсдэл бага гэж тооцсон болно.

## **2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавинажилласан байна.

ЦЕГ-ын Автобааз 2014 онд батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 2,899.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр 2,871.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Өөрийн орлогын төлөвлөгөө 66,37 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр тайлант хугацаанд нийт 66,41 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөө нийт 40,8 мянган төгрөгөөр давсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлийг төрөл тус бүс бүрээр нь үзүүлбэл: жолооны курсын төлбөр 37,3 сая, түрээсийн орлого 5,4 сая, сэлбэгийн төлбөр 1,1 сая бусад төлбөр тооцооны орлогоос 22,5 сая төгрөг төлвөлрүүлсэн байна.

Батлагдсан төсвийн дагуу тус баазын нийт зарлага 2,966.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,938.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 99,1 хувь 27,6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.



ЦЕГ-ын Автобаазын 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

ЭМХТ-ийн 2014 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,887.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 77,7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 34 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорил хэрэгжүүлэхэд явцад бий болсон үр дүнгийн талаар ажлын баримтаар баталгаажуулж, цаашид анхаарах зарим асуудлыг энэ тайлангийн 2.10-д тусгав.

## **2.9 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 42 хувь, нийт зардлын 38 хувийг тус тус эзэлж байна.

## **2.10 Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараахалдаа илэрсэн байна. Үүнд:

### **2.10.1 Үндсэн бус үйл ажиллагааны орлогын талаар**

ЦЕГ-ын Автобаазын санхүүгийн тайланд 2014 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийх явцад 14 байгууллага, иргэдээс өгсөн 7,2 сая төгрөгийн хандив, туслах аж ахуйн түүхий эдийн орлого 1,3 сая төгрөгийг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй байжээ.

Энэ нь иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Шийдвэрлэсэн нь:**

Аудитын явцад холбогдох шийдвэрийг гаргуулж, хандив болон туслах аж ахуйн орлогыг 2014 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж, аудитын явцад залруулав.

## 2.10.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн талаар

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд 2013 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 19,171,00 төгрөгийг тусгаагүй орхисныг аудитын явцад залруулав.

### Шийдвэрлэсэн нь:

Дээрх зөрчлийг аудитын явцад бүрэн зарлуулж, санхүүгийн тайланг шинэчлэн гаргуулав.

## 2.10.3 Автомашины ашиглалт, зориулалт, түлш, шатахууны зардлын талаар

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэлийн 59,3 хувийг дангаараа эзэлсэн тээвэр, шатахууны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэл, тайланд хэрхэн тусгасан эсэхийг төлөвлөсөн горимын дагуу сорьж үзлээ.

ЦЕГ-ын харъяа алба, газар, нэгжийн 292 автомашины шатахууны зардалд 2014 онд 547,6 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 532,05 сая төгрөг зарцуулсан байна.

ЦЕГ-ын даргын 2014 оны 157 дугаар тушаалаар автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээг автомашин тус бүрээр баталгаажуулсан байна.

Дээрх норм нормативыг гүйцэтгэлтэй нь харьцуулан үзэхэд нийт автомашины 99,8 хувь буюу 235 автомашин тогтоосон норм нормативыг хэтрүүлжээ.

Түлш, шатахууны зардал автобаазын хувьд нийт дүнгээрээ хэмнэсэн нь төлөвлөсөн боловч зарцуулаагүй шатахууныг автомашин хооронд гүйлгэж зарцуулсан болон ЦЕГ-аас хоорондын тооцоогоор 182,0 сая төгрөгийн шатахуун олгосонтой холбоотой байна.

ЦЕГ-ын автомашины ашиглалт, зориулалт "Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын зарим заалттай нийцэхгүй байна.

Баазын хэмжээнд 292 автомашины шатахуун, тослох материал, сэлбэг зарцуулалтын тооцоог гар аргаар хийх байгаа нь эдгээртэй холбоотой тооцоо судалгаа гаргахад хүн хүч, цаг хугацаа шаардсан нүсэр ажиллагаатай тул зарим тооцоо судалгаа эцэслэн гараагүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Автомашины ашиглалт, зориулалт, түлш, тослох материал, шатахууны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг системийн хэмжээнд тооцоолж, судлан үр дүнг ЦЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад эцэслэн баталгаажуулж, үнэлэлт өгөхөөр шийдвэрлэв.

## 2.10.4 Үндсэн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах талаар

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тус баазын үндсэн хөрөнгийн 2014 оны жилийн эцсийн үлдэгдэлд төлөвлөсөн горимын дагуу хэсэгчилсэн тооллого хийхэд шатахуун түгээх станцын 21,7 сая төгрөгийн 2 хэсэг хэсэг зам талбай, 7,9 сая төгрөгийн явган хүний гүүр, хашлага цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Тухайлбал шатахуун түгээх станцын суурин дээр ажиллагсдын орон сууц барихаар шийдвэрлэж, газрыг нь өөрийн эзэмшлийн газраас хасч төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна. Дээрх зам талбай тус баазын эзэмшил газраас гарсан тул цаашид ашиглах боломжгүй юм. Харин 7,9 сая төгрөгийн явган хүний гүүр хашлагатай зэрэгцүүлэн төсвийн хөрөнгөөр гүүр барьсан тул уг гүүрийг ашиглахгүй болжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д заасан "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах талаар зөвлөмж боловсруулж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 2.10.5 Төрийн өөрийн хөрөнгийн талаар

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайланд тусгасан төрийн өөрийн хөрөнгийн хэмжээг улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүд холбогдох хууль тогтоомжид нийцэж баталгаажсан байх ёстой гэсэн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн өөрийн хөрөнгийн хэмжээг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөхөөршийдлээ.

#### 2.11 Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Аудитын явцад мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайланд тусгахтай холбоотой 19,171.00 төгрөгийн алдааг залруулсан болно.

#### 2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### 2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй түлш шатахуун, сэлбэг зарцуулалтын зарим эрсдэлтэй асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй. Гэвч энэ нь тайлангийн санал дүгнэлтийн хэлбэрт нөлөөлөхгүй гэж үзлээ.

#### 2.14 Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 38.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 8,5 сая төгрөгийн зөрчлийг залруулав.

#### **2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

ЦЕГ-ын Автобааз 2012 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт авсан бөгөөд 3 зөвлөмж, 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар ЦЕГ-ын нэгдсэн тайланд тусгагдсан Автобаазтай холбоотой 1 зөвлөмжийг биелүүлжээ.

#### **2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

#### **2.17 Шилэн дансны мэдээлэл**

Тус бааз үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд санхүү, худалдан авалт, байгууллагын төсөв, хагас, бүтэн жилийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, төлбөрт үйлчилгээний үнэ тариф, журам зааварыг нээлттэй ил тодоор мэдээлж ирсэн байна.

Үүний дотор 2015 оноос Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор урсгал төсвийн зардлыг гүйлгээ бүрээр сар тутам мэдээлдэг болжээ.

**ГУРАВ. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
АВТОБААЗЫН 2014ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

[enkhzayas@audit.gov.mn](mailto:enkhzayas@audit.gov.mn)

Аудитын менежер: Л.Одгэрэл

Утас: 261628

Цахим хаяг:

[odgerell@audit.gov.mn](mailto:odgerell@audit.gov.mn)

Ахлах аудитор Ж.Батсайхан

Утас: 261839

Цахим хаяг:

[batsaikhanj@audit.gov.mn](mailto:batsaikhanj@audit.gov.mn)

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр

Бага тойруу 6

Улаанбаатар-46

Монгол улс

Цахим хуудас: [www.mnao.mn](http://www.mnao.mn)

2014 оны 2 дугаар сар

**Менежментийн захидал**

Агуулга

Тэргүүлэх ач холбогдолын дарааллаар жагсаав:

Асуудал 1

Автомашин ашиглалт, шатахууны зардлын талаар

Асуудал 2

Үндсэн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах талаар

Асуудал 3

Төрийн өөрийн хөрөнгийн талаар

### 3.1 Менежментийн захидлын тайлбар, тодруулга:

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

### 3.2 Аудитын зөвлөмж:

Энэ тайланд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

<b>Асуудал 1</b> Автомашины ашиглалт, шатахууны зардлын талаар	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
--	----------------------------------

#### **Ажиглалт**

ЦЕГ-ын харъяа алба, газар, нэгжийн 292 автомашины шатахууны зардалд 2014 онд 547,6 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 532,05 сая төгрөг зарцуулсан байна.

ЦЕГ-ын даргын 2014 оны 157 дугаар тушаалаар автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээг автомашин тус бүрээр баталгаажуулсан байна. Дээрх норм нормативыг гүйцэтгэлтэй нь харьцуулан үзэхэд нийт автомашины 99,8 хувь буюу 235 автомашин тогтоосон норм нормативыг хэтрүүлжээ.

Түлш, шатахууны зардал автобаазын хувьд нийт дүнгээрээ хэмнэсэн нь төлөвлөсөн боловч зарцуулаагүй шатахууныг автомашин хооронд гүйлгэж зарцуулсан болон ЦЕГ-аас хоорондын тооцоогоор 182,0 сая төгрөгийн шатахуун олгосонтой холбоотой байна.

ЦЕГ-ын автомашины ашиглалт, зориулалт "Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын зарим заалттай нийцэхгүй байна.

Баазын хэмжээнд 292 автомашины шатахуун, тослох материал, сэлбэг зарцуулалтын тооцоог гар аргаар хийх байгаа нь эдгээртэй холбоотой тооцоо судалгаа гаргахад хүн хүч, цаг хугацаа шаардсан нүсэр ажиллагаатай тул зарим тооцоо судалгаа эцэслэн гараагүй байна.

#### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай батламж мэдэгдэл зөрчигдөх эрсдэл байна.

Үүнд:

- Үнэн зөв байдал
- Иж бүрэн байх
- Тохиолдсон байх
- Толилуулга ба илчлэл

#### **Зөвлөмж**

Автомашины зориулалт, ашиглалтыг хянах, сэлбэг, түлш шатахууны орлого, зарцуулалтын тооцоог програмчлан цахим хэлбэрт шилжүүлж, эдгээр зардал, үйл ажиллагааг хянаж, удирдах боломж нөхцлийг хангах

#### **Үйлчлүүлэгчийн хариу**

ЦЕГ-ын Автобаазын удирдлага асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

**Асуудал 2 Үндсэн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Ажиглалт**

Тус баазын үндсэн хөрөнгийн 2014 оны жилийн эцсийн үлдэгдэлд төлөвлөсөн горимын дагуу хэсэгчилсэн тооллого хийхэд шатахуун түгээх станцын 21,7 сая төгрөгийн 2 хэсэг хэсэг зам талбай, 7,9 сая төгрөгийн явган хүний гүүр, хашлага цаашид ашиглах боломжгүй болсон байна.

Тухайлбал шатахуун түгээх станцын суурин дээр ажиллагсдын орон сууц барихаар шийдвэрлэж, газрыг нь өөрийн эзэмшлийн газраас хасч төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна. Дээрх зам талбай тус баазын эзэмшил газраас гарсан тул цаашид ашиглах боломжгүй юм. Харин 7,9 сая төгрөгийн явган хүний гүүр хашлагатай зэрэгцүүлэн төсвийн хөрөнгөөр гүүр барьсан тул уг гүүрийг ашиглахгүй болжээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-д заасан "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэсэн заалттай зөрчилдөж байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн талаарх батламж мэдэгдэл зөрчигдөх

**Зөвлөмж**

Зам талбай, явган хүний гүүрийг цаашид ашиглах эсэхийг зохих журмын дагуу тогтоож, холбогдох шийдвэр гаргуулах асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

ЦЕГ-ын Автобаазын удирдлага асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан болно.



<b>Асуудал 3Төрийн өөрийн хөрөнгийн Талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
--	----------------------------------

**Ажиглалт**

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайланд тусгасан төрийн өөрийн хөрөнгийн хэмжээг улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүд холбогдох хууль тогтоомжид нийцэж баталгаажсан байх ёстой гэсэн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

**Зөвлөмж**

Төрийн өөрийн хөрөнгийн хэмжээг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн талаарх батламж мэдэгдэл зөрчигдөх

**Үйлчлүүлэгчийн хариу**

ЦЕГ-ын Автобаазын удирдлага асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан болно.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЦЕГ-ын Автобаазын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Баталгаажуулалт:

АУДИТЫН ТАЙЛАНГ

**ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ЭНХЗАЯА

**АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Л.ОДГЭРЭЛ

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

 Ж.БАТСАЙХАН

2014.02.11

## 4. Хавсралт:

## Хавсралт №1 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант үе: 2014/01/01 - 2014/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	13.12.31	14.12.31
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>19 171</b>	<b>0</b>
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө	19 171	0
310201	Төгрөг	19 171	0
31020104	Төсөвт байгууллагын харилцах (Арилжааны)	19 171	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>172 488 354</b>	<b>196 102 655</b>
3501	Түүхий эд материал	8 535 136	8 516 456
350101	Тусгай зориулалттай материал	8 209 329	8 209 329
350102	Эм боох материал	325 807	307 127
3503	Бэлэн бүтээгдэхүүн	4 508 100	2 638 140
3504	Хангамжийн материал	157 314 118	182 544 058
350401	Бичиг хэргийн материал	3 819 231	3 958 571
350402	Аж ахуйн материал	33 172 387	49 916 071
350403	Сэлбэг хэрэгсэл	21 556 942	28 636 919
350404	Түлш, шатах тослох материал	55 294 253	56 762 832
350409	Бусад хангамжийн материал	43 471 305	43 269 665
3505	Мал амьтад	2 131 000	2 404 000
<b>1</b>	<b>НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>172 507 525</b>	<b>196 102 655</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6 968 801 691</b>	<b>6 830 697 973</b>
<b>3902</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6 968 801 691</b>	<b>6 830 697 973</b>
390201	Барилга, байгууламж, орон сууц	2 900 024 765	2 845 923 459
39020101	Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	3 652 793 395	3 638 452 435
39020102	Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(752 768 630)	(792 528 976)
390202	Авто-тээврийн хэрэгсэл	3 863 619 245	3 808 459 121
39020201	Авто-тээврийн хэрэгсэл - Анхны өртөг	7 540 060 834	7 930 002 727
39020202	Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(3 676 441 588)	(4 121 543 606)
390203	Машин тоног төхөөрөмж(компьютер)	88 163 018	66 510 704
39020301	Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	269 040 444	227 041 052
39020302	Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(180 877 426)	(160 530 347)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	38 430 135	37 073 097
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	64 304 075	66 187 995
39020402	Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(25 873 941)	(29 114 898)
<b>390208</b>	<b>Бусад үндсэн хөрөнгө</b>	<b>78 564 528</b>	<b>72 731 592</b>
39020801	Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	484 887 190	403 506 090
39020802	Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(406 322 662)	(330 774 498)

УАГ-2015/52/СТА/-ТШЗ

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

39030101	Програм хангамж - Анхны өртөг	1 067 500	1 067 500
39030102	Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(1 067 500)	(1 067 500)
<b>2</b>	<b>НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b><u>6 968 801 691</u></b>	<b><u>6 830 697 973</u></b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7 141 309 216</u></b>	<b><u>7 026 800 628</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	13 188 828 907	13 188 828 907
5101	Засгийн газрын сан	13 188 828 907	13 188 828 907
5103	Хуримтлагдсан үр дүн	(6 071 914 667)	(6 186 423 255)
510301	Өмнөх үеийн үр дүн	(6 071 914 667)	(6 071 914 667)
510302	Тайлант үеийн үр дүн		(114 508 588)
5104	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24 394 976	24 394 976
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7 141 309 216</u></b>	<b><u>7 026 800 628</u></b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7 141 309 216</u></b>	<b><u>7 026 800 628</u></b>

## Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант үе: 2014/01/01 - 2014/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	13.12.31	14.12.31
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,949,368,840</b>	<b>4 191 543 057</b>
1303	Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	4,949,368,840	4 191 543 057
130301	Улсын төвлөрсөн төсвөөс	2 449 114 480	2 872 009 900
13030101	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2 449 114 480	2 872 009 900
130306	Системийн дотоод санхүүжилт	1 481,103,902	1 319 533 157
13030602	Хөрөнгийн санхүүжилт/орон нутгаас/	1,019,150,458	
<b>14</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>113,215,775</b>	<b>78 601 024</b>
1402	Бараа, үйлчилгээний борлуулалт	113 215 775	75 806 724
140201	Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	113 215 775	75 806 724
14020102	Аж ахуйн нэгж байгууллагаас	104 513 535	66 410 829
14020105	Үнэ төлбөргүй авсан орлого	8 702 240	9 395 895
1405	Татварын бус бусад орлого		2 794 300
140502	Хөрөнгийн орлого		2 794 300
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,062,584,615</b>	<b>4,270,144,081</b>
<b>21</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>	<b>1 709 241 079</b>	<b>2 037 542 031</b>
2101	Үндсэн болон нэмэгдэл цалин	1 659 965 316	1 977 995 830
210101	Үндсэн цалин	1 194 872 826	1 269 644 101
210102	Нэмэгдэл цалин	465 092 490	708 351 729
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	49 275 763	59 546 201
210202	Эрүүл мэндийн даатгалын хураамж	49 275 763	59 546 201
<b>22</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,105,821,262</b>	<b>2 200 136 808</b>
2201	Бараа үйлчилгээний урсгал зардал	2,063,926,262	2 199 211 808
220101	Тогтмол зардал	124 838 947	82 952 500
22010101	Гэрэл цахилгаан	42 990 412	31 914 003
22010102	Түлш, халаалт	78 164 941	44 981 106
22010103	Цэвэр, бохир ус	3 683 594	6 057 391
220102	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	11 716 043	3 847 170
22010201	Хоол	11 701 850	3 828 490
22010202	Эм, вакцин	14 193	18 680
220103	Бусад бараа үйлчилгээний зардал	1,878,274,595	2 112 412 138
22010301	Бичиг хэргийн зардал	8 623 199	5 822 940
22010302	Тээвэр, шатахуун	513 161 014	714 707 027
22010303	Шуудан, харилцаа холбоо	3 682 600	2 653 100
22010304	Дотоод албан томилолт	19 404 990	18 404 000
22010306	Ном, хэвлэл захиалах, худалдан авах	65 230	211 900
22010307	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	1 269 170	1 669 920
22010310	Жижиг эд хогшил худалдан авах	6,824,238	13 602 890

## ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

220103103	Жижиг эд хогшил худалдан авах (Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл)	859	1 026 316
220103104	Жижиг эд хогшил худалдан авах (Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс)	6,823,379	12 576 574
22010311	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	4 333 302	6 352 816
22010312	Төлбөр хураамж, жижиг татварууд		1 443 740
22010315	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1 014 800	3 854 200
2201031505	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1 014 800	589 200
2201031515	ТӨГАҮ (Тээврийн хэрэгслийн оношилгоо)		3 265 000
22010317	Урсгал засвар	237 159 471	233 112 410
22010320	Бусад зардал	2 408 960	
22010322	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,066,249,642	1 107 177 195
22010323	Аж ахуйн материал худалдан авах зардал		
22010324	Бараа материал акталсны зардал	10 793 562	
22010325	Газрын төлбөр	2 849 616	3 400 000
22010332	Товхимол, тараах материал	434 800	
2202	Хөтөлбөр арга хэмжээний зардал	41 895 000	925 000
220201	Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	3 105 000	925 000
22020101	Мал аж ахуйн үржлийн зардал	3 105 000	925 000
220203	Дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа хөтөлбөр төсөл, арга хэмжээ	38 790 000	
22020301	Дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа	38 790 000	
<b>26</b>	<b>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26 621 677</b>	<b>77 367</b>
2603	Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	26 621 677	77 367
260302	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26 621 677	77 367
26030202	Төвлөрүүлэх шилжүүлэг	26 621 677	77 367
<b>27</b>	<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>22 475 000</b>	<b>20 076 140</b>
2703	Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	22 475 000	20 076 140
270301	Мөнгөн хэлбэрээр	2 350 000	6 000 000
27030101	Нэг удаагийн тэтгэмж	2 350 000	6 000 000
270312	Шагнал, урамшил	1 125 000	
270606	Тээврийн хэрэгслийн татвар	19 000 000	14 076 140
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3 249 000 341</b>	<b>4 257 832 346</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>1 247 522 274</b>	<b>12 311 735</b>
140503	Хөрөнгийн худалдсаны олз	35 972 222	30 440 570
14050304	Үндсэн хөрөнгө худалдсаны олз	35 972 222	30 440 570
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>35 972 222</b>	<b>30 440 570</b>

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2802	Бусад зардал ба алдагдал	71 649 287	157 260 893
280202	Хөрөнгийн худалдсаны гарз	71 649 287	157 260 893
28020202	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	71 649 287	157 260 893
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>71 649 287</u></b>	<b><u>157 260 893</u></b>
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b><u>1,211,845,209</u></b>	<b><u>(114,508,588)</u></b>

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе: 2014/01/01 - 2014/12/31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	13.12.31	14.12.31
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2 449 819 567</b>	<b>2 872 009 900</b>
130101	Урсгал	2 449 114 480	2 872 009 900
1303	Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	705 087	0
130304	Нийгмийн даатгалын сангаас	705 087	0
13030404	ЭМДС-ийн шилжүүлэг	705 087	
<b>14</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104 513 535</b>	<b>66 410 829</b>
1402	Бараа, үйлчилгээний борлуулалт	104 513 535	66 410 829
140201	Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	104 513 535	66 410 829
14020102	Аж ахуйн нэгж байгууллагаас	104 513 535	66 410 829
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2 554 333 102</b>	<b>2 938 420 729</b>
<b>21</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>	<b>1 709 946 166</b>	<b>2 034 784 433</b>
2101	Үндсэн болон нэмэгдэл цалин	1 683 150 166	2 000 444 933
210101	Үндсэн цалин	1 683 150 166	2 000 444 933
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	26 796 000	34 339 500
210202	Эрүүл мэндийн даатгалын хураамж	26 796 000	34 339 500
<b>22</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>795 171 088</b>	<b>878 578 100</b>
2201	Бараа үйлчилгээний урсгал зардал	795 171 088	878 578 100
220101	Тогтмол зардал	124 838 947	82 952 500
22010101	Гэрэл цахилгаан	42 990 412	31 914 003
22010102	Түлш, халаалт	78 164 941	44 981 106
22010103	Цэвэр, бохир ус	3 683 594	6 057 391
220102	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	9 480 700	3 053 820
22010201	Хоол	9 480 700	3 053 820
220103	Бусад бараа үйлчилгээний зардал	660 851 441	792 571 780
22010301	Бичиг хэргийн зардал	3 034 800	2 993 400
22010302	Тээвэр, шатахуун	413 999 000	532 059 200
22010303	Шуудан, харилцаа холбоо	4 044 000	2 653 100
22010304	Дотоод албан томилолт	19 404 990	13 573 500
22010306	Ном, хэвлэл захиалах, худалдан авах	500 000	331 900
22010307	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	1 507 000	1 346 000
22010310	Жижиг эд хогшил худалдан авах	18 754 863	15 098 100
220103101	Жижиг эд хогшил худалдан авах (Багаж хэрэгсэл)	3 676 559	3 550 036
220103103	Жижиг эд хогшил худалдан авах (Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл)	6 778 018	6 899 964

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

220103104	Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	8 300 286	4 648 100
22010311	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	9 000 000	7 770 380
22010312	Төлбөр хураамж, жижиг татварууд		2 000 000
22010315	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1 344 460	4 346 200
2201031505	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1 344 460	1 081 200
2201031515	ТӨГАҮ \Тээврийн хэрэгслийн оношилгоо\		3 265 000
22010317	Урсгал засвар	184 412 712	207 000 000
22010325	Газрын төлбөр	2 849 616	3 400 000
22010332	Товхимол, тараах материал	2 000 000	
<b>26</b>	<b><u>ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ</u></b>	<b>26 621 677</b>	<b>77 367</b>
2603	Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	26 621 677	77 367
260302	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26 621 677	77 367
26030202	Төвлөрүүлэх шилжүүлэг	26 621 677	77 367
<b>27</b>	<b><u>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</u></b>	<b>22 575 000</b>	<b>25 000 000</b>
2703	Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	22 575 000	25 000 000
270301	Мөнгөн хэлбэрээр	1 850 000	6 000 000
27030101	Нэг удаагийн тэтгэмж	1 850 000	6 000 000
270312	Шагнал, урамшил	1 725 000	
270606	Тээврийн хэрэгслийн татвар	19 000 000	19 000 000
<b>2</b>	<b><u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</u></b>	<b><u>2 554 313 931</u></b>	<b><u>2 938 439 900</u></b>
<b>3</b>	<b><u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</u></b>	<b><u>19 171</u></b>	<b><u>-19 171</u></b>
<b>8</b>	<b><u>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</u></b>	<b><u>19 171</u></b>	<b><u>-19 171</u></b>
<b>9</b>	<b><u>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u></b>		<b>19 171</b>
<b>10</b>	<b><u>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u></b>	<b>19 1710</b>	<b>0</b>



## Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант үе: 2014/01/01 -  
2014/12/31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	<b>2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	10 410 502 298	31 740 013	(6 283 457 103)	4 158 785 207
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7 154 755	7 154 755
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10 410 502 298	31 740 013	(6 276 302 348)	4 165 939 963
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(7 154 755)		(7 154 755)
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
	Тайлант үеийн үр дүн	2 778 326 609		-1 007 647 809	1 770 678 799
2	<b>2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	13 188 828 907	24 394 976	(6 071 914 667)	7 141 309 216
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13 188 828 907	24 394 976	(6 071 914 667)	7 141 309 216
	Үндсэн хөрөнгийн өсөлт/бууралт				
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт				
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
	Тайлант үеийн үр дүн			(114 508 588)	(114 508 588)
3	<b>2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	13 188 828 907	24 394 976	(6 186 423 255)	7 026 800 628

## Хавсралт №2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,965,990,200	2,938,362,533	27,627,667	99.1
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,965,990,200	2,938,362,533	27,627,667	99.1
3.1	Бараа, үйлчилгээний зардал	2,959,990,200	2,932,362,533	27,627,667	99.1
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,000,445,700	2,000,444,933	767	100.0
4.1	Үндсэн цалин	1,939,764,000	2,000,444,933	-	103.1
4.2	Гэрээтийн цалин	60,681,700	-	60,681,700	-
4.3	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,339,500	34,339,500	-	100.0
4.4	Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	34,339,500	34,339,500	-	100.0
5	Бараа, үйлчилгээний бусад зардал	925,205,000	897,578,100	27,626,900	97.0
5.1	Бичиг хэрэг	3,508,000	2,993,400	514,600	85.3
5.2	Гэрэл цахилгаан	30,728,600	31,914,003	1,185,403	103.9
5.3	Түлш, халаалт	58,726,800	44,981,106	13,745,694	76.6
5.4	Тээвэр (шатахуун)	547,639,100	532,059,200	15,579,900	97.2
5.5	Шуудан холбоо	2,772,000	2,653,100	118,900	95.7
5.6	Цэвэр, бохир ус	5,344,800	6,057,391	712,591	113.3
5.7	Дотоод албан томилолт	13,582,600	13,573,500	9,100	99.9
5.8	Ном хэвлэл авах	2,550,000	331,900	2,218,100	13.0
5.9	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,615,000	1,346,000	269,000	83.3
5.10	Эд хогшил худалдан авах	20,043,400	15,098,100	4,945,300	75.3
5.11	Жижиг эд хогшил худалдан авах (Багаж хэрэгсэл)	5,669,900	3,550,036	2,119,864	62.6
5.12	Жижиг эд хогшил худалдан авах (Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл)	11,050,000	6,899,964	4,150,036	62.4
5.13	Жижиг эд хогшил худалдан авах (Бага үнэ түргэн элэгдэл зүйлс)	3,323,500	4,648,100	1,324,600	139.9
5.14	Нормын хувцас зөөлөн эдлэл	9,650,000	7,770,380	1,879,620	80.5
5.15	Хоол	3,155,700	3,053,820	101,880	96.8
5.16	Урсгал засвар	197,000,000	207,000,000	10,000,000	105.1
6	Төлбөр хураамж болон бусад зардал	2,000,000	2,000,000	-	100.0
6.1	Төлбөр хураамж бусад зардал	2,000,000	2,000,000	-	100.0
7	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	23,489,000	23,346,200	142,800	99.4
7.1	ТӨГАҮйлчилгээ	1,224,000	1,081,200	142,800	88.3

ЦЕГ-ын Автобаазын 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

7.2	ТӨГАУ Харуул, хамгаалалтын хөлс	3,265,000	3,265,000	-	100.0
7.3	ТӨГАУ Тээврийн хэрэгслийн татвар	19,000,000	19,000,000	-	100.0
7.4	Газрын төлбөр	3,400,000	3,400,000	-	100.0
<b>8</b>	<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>6,000,000</b>	<b>6,000,000</b>	-	<b>100.0</b>
8.1	Өрх гэрт олгох шилжүүлэг	6,000,000	6,000,000	-	100.0
8.2	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,000,000	6,000,000	-	100.0
<b>9</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b><u>2,965,990,200</u></b>	<b><u>2,938,343,362</u></b>	<b><u>27,646,838</u></b>	<b><u>99.1</u></b>
9.1	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,370,000	66,410,829	40,829	100.1
9.2	Төсвөөс санхүүжих	2,899,620,200	2,871,932,533	27,687,667	99.0
	<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>19,171</b>	<b>19,171</b>	-
	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>10</b>	<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>248</b>	<b>243</b>	<b>5</b>	<b>98.0</b>
10.1	Удирдах ажилтан	2	2	-	100.0
10.2	Гүйцэтгэх ажилтан	212	209	3	98.6
10.3	Үйлчлэх ажилтан	34	32	2	94.1

ЦЕГ-ЫН АВТОБААЗЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС ӨГӨГДСӨН  
ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

ЦЕГ-ын Автобаазын 2013-2014 оны үйл ажиллагаанд йүндэсний Аудитын газраас хийсэн санхүүгийн шалгалтаар өгөдсөн зөвлөмжийн дагуу дараахи ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Улаанбаатар хотын цагдаагийн газрын данс бүртгэлтэй 44 автомашиныг Нийслэлийн засаг даргын 2014 оны А/959 тоот захирамжийн дагуу жолооч нарт нь 2 удаагийн хаалттай дуудлага худалдаагаар оруулж худалдсан. Үүнээс зарагдсан 33 автомашины баримт материалыг бүрдүүлэн данс бүртгэлээс хасч бүртгэсэн.
2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 729 тоот тушаалаар „ Эрдэнэт, үйлдвэрээс хандиваар орлогод авсан Кароса маркийн 04-29 ОРА автомашины Төрийн өмчийн хорооны тогтоол гаргаагүй байна. Эрдэнэт үйлдвэрийнхэн холбогдох материалыг өөрийн хариуцсан мэргэжилтэнд ирүүлээгүй шалтгаанаар тогтоол гарахгүй удааширч байна.
3. Автобаазын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 21 автомашиныг Төрийн өмчийн хорооны тогтоолын дагуу 2 удаа дуудлага худалдаагаар оруулж, 7 автомашин зарагдсан. Дуудлага худалдаагаар зарагдсан 7 автомашины баримт материалыг бүрдүүлэн данс бүртгэлээс хасч бүртгэсэн. Зарагдаагүй 14 автомашины үнийг 50 хувь бууруулан худалдах саналаа Санхүү хангамжийн газарт албан тоотоор хүргүүлээд Төрийн өмчийн хорооны шийдвэрийг хүлээж байна.

Хавсарсан материал хуудас

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧ

ЦАГДААГИЙН ХОШУУЧ

С.ОТГОНТӨГС